

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл.....	4
Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төслийн байршил.....	4
1.3. Үйлдвэрийн бүтэц зохион байгуулалт.....	7
1.4. Төслийн дэд бүтэц.....	9
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	15
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	18
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	25
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд .....	4
Хүснэгт 2. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр .....	15
Хүснэгт 3. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал .....	18
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
Хүснэгт 5. Орчны хяналт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	21
Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	22
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	24
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	25
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	26
Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	27

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг .....	5
Зураг 2. Засаг захиргааны зураг .....	6
Зураг 3. Үйлдвэрийн гадна талбайн харагдах байдал.....	8
Зураг 4. Үйлдвэрийн дотор талбайн харагдах байдал .....	8
Зураг 5. Ажилчдын ариун цэвэрийн өрөө.....	8
Зураг 6. Ажилчдын гал тогоо.....	8
Зураг 7. Ажилчдын амрах өрөө.....	8
Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим .....	11
Зураг 9. Салхины хурдны жилийн явц.....	12
Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018) .....	12
Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт .....	12

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

“Жэй Эйч Жэй Мандухай” ХХК нь Монгол-Хятадын хамтарсан гадаадын хөрөнгө оруулалттай 2019 оны 4 дүгээр сарын 11-нд үүсгэн байгуулагдаж, гадаад худалдаа, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн түүхий эдийн худалдаа, газар тариалан, мал аж ахуй, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаа, барилгын засвар, үл хөдлөх хөрөнгийн худалдааны чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулах зорилготойгоор ажиллаж байна.

### Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр:
  - “Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр”-ийн төсөл
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:
  - “Жэй Эйч Жэй Мандухай” ХХК
  - Хувийн хэргийн дугаар: 9019066107
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:
  - Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, хайрхан 6-27 тоот
  - Утас: 99066263, 99120363

### 1.2. Төслийн байршил

“Жэй Эйч Жэй Мандухай” ХХК-ийн “Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр” нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар-баруун аймгуудыг холбосон хатуу хучилттай автозамаас урагш 1 км орчим зайд байрладаг.

- Талбайн хэмжээ: 19717.3 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48-10

### Газарзүйн солбицол

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	40	23.4	47	53	30.6
2	106	40	23.1	47	53	34.6
3	106	40	30.8	47	53	34.8
4	106	40	31.1	47	53	30.8



Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг





Зураг 2. Засаг захиргааны зураг

### **1.3. Үйлдвэрийн бүтэц зохион байгуулалт**

Тус компанийн дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр нь 2019 оны 7 дугаар сард ашиглалтад орж, бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлсэн бөгөөд хоногт дунджаар 1.12 тонн буюу жилдээ нийт 367,5 тонн адуу, үхэр, хонь, ямааны махыг дулааны аргаар боловсруулж, тус бүр нь 5.0 кг цэвэр жинтэйгээр савлагдсан 55,12 мянган ширхэг буюу нийт 275,6 тонн вакумдаж савласан махан бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөгдсөн юм.

Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа нь малын махыг зориулалтын хөргөгчид болон гүн хөлдөөгчид нөөцөлж хадгалах, хадгалсан махаа стандартын шаардлага хангасан өрөөнд гэсгээх, угаах, шулах, ангилж хэрчих, хэмжиж савлан дулааны аргаар чанах, эцсийн бүтээгдэхүүнийг савлаж баглах дамжлага хэсгүүдээс бүрдэнэ. Үйлдвэрийн түүхий эд болох адуу, хонь, ямаа, үхрийн махыг эрүүл ахуй, мах бэлтгэлийн зохих шалгууруудыг хангасан малчид болон мах бэлтгэлийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан худалдан авч байна.

Үйлдвэрлэлийн нийт байгууламж нь 606,3м<sup>2</sup> талбай бүхий хөргөлттэй хадгалах 2 агуулах, нийт 107,5 м<sup>2</sup> талбай бүхий гүн хөлдөөх 3 агуулах, 1824,9 м<sup>2</sup> талбай бүхий үндсэн үйлдвэрийн технологийн хэсэгтэй. Гүн хөлдөөгч тус бүр нь 50 тонн мах хадгалах багтаамж бүхий хүчин чадалтай ба хөргөлттэй хадгалах 3 агуулах тус бүр цэвэр багтаамжаар 630 тонн мах хадгалах хүчин чадалтай, гүн хөлдөөх болон хөргөлтийн хэсгийн 5 агуулахад нийтдээ 1500 тн махыг нэгэн зэрэг хадгалах хүчин чадалтай. Тус үйлдвэр нь мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн инженер, технологич, эрүүл ахуйч нар бүхий чадварлаг ажилтан, ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг эрхэм болгодог манай компани нь өндөр нарийвчлалтай микроскоп, электрон жин, термостат, автоклав зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон дотоод хяналтын лабораторитой. Лаборатори нь бүтээгдэхүүнд өдөр тутмын хяналт шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн чанарын баталгаа олгохын зэрэгцээ үйлдвэрлэлийн орчны болон ажилчдын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд микробиологийн шинжилгээ тогтмол хийж байнгын хяналт тавин ажиллаж хэвшээд байна.

Тус компанийн хамт олон маань түүхий махыг хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын өндөр түвшинд үйлдвэрлэлийн аргаар боловсруулж, эх орныхоо мах махан бүтээгдэхүүний экспортын чадавхыг нэмэгдүүлэхэд өөрийн зохих хувь нэмрээ оруулахаар итгэл дүүрэн ажиллаж байна.



Зураг 3. Үйлдвэрийн гадна талбайн харагдах байдал



Зураг 4. Үйлдвэрийн дотор талбайн харагдах байдал




Зураг 5. Ажилчдын ариун цэвэрийн өрөө





Зураг 6. Ажилчдын гал тогоо



Зураг 7. Ажилчдын амрах өрөө

#### 1.4. Төслийн дэд бүтэц

- Усан хангамж: Төвлөрсөн эх үүсвэрээс хангана
- Цахилгаан хангамж: Төвлөрсөн эх үүсвэрээс хангана;
- Дулаан хангамж: Төвлөрсөн эх үүсвэрээс хангана;

## **2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1. Монгол орны уур амьсгал**

Монгол орон гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евроазийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын гол онцлог нь жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм (УАӨҮИ, 2014). Уур амьсгалыг ихэнхдээ температур, хур тунадас, салхи зэрэг газрын гадарга орчмын цаг уурын хэмжигдэхүүнийг ашиглан илэрхийлдэг. Жилийн дундаж агаарын температур Монгол орны өндөр уулын бүс тэдгээрийн хоорондын хөндий, хоолой, томоохон голын хөндийгөөр  $-6^{\circ}\text{C}$  аас  $-8^{\circ}\text{C}$  хүртэл хүйтэн байдаг бол өмнийн говь, цөл нутагт  $6^{\circ}\text{C}$  -аас дулаан байна. Өөрөөр хэлбэл, жилийн дундаж агаарын температур нь манай орны баруун болон хойд хэсгийн уулархаг нутагт хасах, харин түүнээс урагших тал хээр говь цөлийн нутгаар нэмэх утгатай байдаг байна. Монгол орон ерөнхийдөө хуурай, хуурайвтар уур амьсгалын бүсэд орших тул хур тунадас бага ордог. Өндөр уулсын таг, тундрийн бүсэд 400 мм ээс дээш Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 50-150 мм орчим хур тунадас унана. Мөн өргөн уудам нутагтай, газрын тогтоц, хотгор гүдгэрийн байдал, газарзүйн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан хур тунадас хойноос урагш, зүүнээс баруун тал руу буурдаг бөгөөд ордог хур тунадасны 80-аас дээш хувь нь дулааны улиралд түүний дийлэнх нь 7 болон 8 сард ордог орон онцлогтой (Дагвадорж. Д, 2015).


### **2.2. Улаанбаатар хотын уур амьсгалын горим**

Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүйтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1300 м орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур  $-0.3^{\circ}\text{C}$  байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд  $-21^{\circ}\text{C}$ , зуны улиралд  $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар  $23.7^{\circ}\text{C}$  орчим байна.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна.




Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим

Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 5 дугаар сард ихсэж хамгийн их хур тунадас 7 сард 75.1 мм, намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багасаж, 11 дүгээр сараас өвлийн гормондоо шилжиж 1 сард хамгийн бага хур тунадас буюу дунджаар 2.4 мм унадаг байна. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж, хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 3-р 10 хоногт унах бөгөөд 11 дүгээр сарын дундаас цасан бүрхүүл тогтож, 100 орчим хоног цасан бүрхүүлтэй байж 4 дүгээр сарын эхээр цас хайлж, 5 дугаар сарын эхэн гэхэд дуусна. Сүүлчийн цас хожуудаа 5 дугаар сарын дунд арав хоногт ажиглагддаг. Цасны зузаан 2-4 см байх ба зарим хунгарласан газраа хааяа 10-20 см хүрдэг. Цасны нягт 0.16-0.30 г/см<sup>3</sup> байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 248 мм унадаг үүнээс дулаан улирлын нийлбэр хур тунадас 220мм буюу 89%, харин хүйтний улирлын нийлбэр хур тунадас 28мм буюу 11% ноогдох бөгөөд хур тунадасны хэмжээгээр хээрийн бүсэд хамрагддаг болохыг харуулж байна. Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58,6% байна.


### 2.3. Салхины горим

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт салхины хурд олон жилийн дунджаар 2.4 м/с байдаг нь цаг агаар тогтуун бүс бүс нутаг юм.




Зураг 9. Салхины хурдны жилийн явц

Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр, хоёр тохиож байна. Үндсэн хамгийн их утга нь 5 сард дунджаар 3.3 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард дунджаар 2.6 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 1 сард дунджаар 1.2 м/с, хоёрдугаар бага утга нь 7 сард дунджаар 2.7 м/с тохиодог байна.



Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)

Улаанбаатар станцын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 47.3%-ийн давтагдалтай зонхилох боловч зүүний салхи 15.9% байгаа нь зэргэлдээх зовхисоосоо хавьгүй их давтагдалтай байна. Ялангуяа намар болон өвлийн улиралд энэ зүгийн салхи 13.0-14.3% болж зонхилох зүг болдог. Энэ зүгийн салхины давтагдал хаврын сүүл сард нэлээд буурах боловч зуны саруудад ахин нэмэгддэг (НЗДТГ, 2018).



Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт



1969-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 2.5°C-аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр буй нь Зураг 6-г харагдаж байна.

Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 1969 онд -2.58°C удаах хүйтэн жил -2.0°C байсан бол хамгийн дулаан жил 2007 онд 1.95°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн хандлагаас үзвэл өссөн болон буурсан тодорхой хандлага илрээгүй бөгөөд хур тунадасны хэмжээ 166,2-395,6 мм-ийн хооронд хэлбэлзсэн ба 1966-1981, 1994-2007 онд буурч 2007 оноос эхлэн өсөх хандлагатайгаар өөрчлөгдсөн байна.

**Агаар орчин:** “Дулааны аргаар мах боловсруулах” үйлдвэрийн талбай нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт оршдог бөгөөд БНХАУ-д 2021 оны 5 сард үйлдвэрлэсэн бүх төрлийн түлш хэрэглэдэг НҮ7213 маркийн уурын зуухтай, янданд утаа шүүгч сэнс, үнс баригчтай, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн техникийн баталгаажуулалт хийлгэсэн, “Үндэсний уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-аас “Зөвшөөрлийн бичиг олгох гурвалсан гэрээ”-г байгуулан угаасан нүүрсний /мидлинг/ түлэх зөвшөөрөлтэй.

**Хөрсөн бүрхэвч:** Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн хөрсний дэд бүсийн хүрээнд Хэнтийн захын хөрсний тойрогт хамаарагдана. Улаанбаатар хот орчим нь Хэнтийн өмнөх тойрогт багтах салбар уулсад хамаарагдах бөгөөд тэдгээрийн энгэр хажуу, Туул голын өргөн хөндий орчмын газраар гол төлөв хар хүрэн хөрс зонхилон тархсан байдаг. Харин Туул голын татмын хүрээнд Аллювийн хөрс зонхилох ба тэр дундаа Аллювийн хайрган, ширэгт, нугат, цэвдэгт хөрснүүд голын татамд тархсан байна. Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбайд тал газар, хөндийн хонгорын хөрс тархсан байна.

Хөрсөнд хийлгэсэн шинжилгээний дүнгээс үзвэл стандартаас давсан үзүүлэлт байхгүй тул хөрсөөр дамжин хүн болоод байгаль орчинд үзүүлэх эрсдэл одоогоор байхгүй байна. Тус үйлдвэр нь үйлдвэрийн болон ахуйн хатуу хог хаягдлыг дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулсны үндсэн дээр тухай бүрд нь хугацаа алдалгүй ачилт хийлгэдэг учир хөрсний бохирдол одоогоор үүсээгүй байна.

**Усан орчин:** Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбай болон түүний орчимд гадаргын усан сүлжээ байхгүй, харин төслийн талбайн зүүн урдуур 6 км-ийн зайд Туул гол урсан өнгөрдөг. Төсөл хэрэгжих Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр нь туул голын сав газарт харьяалагдах ба сав газар нь нийт 44.173.00 км<sup>2</sup> талбайг хамран оршино.

“Дулааны аргаар мах боловсруулах” үйлдвэр нь хашаандаа гүний худагтай бөгөөд тус худгаас үйлдвэрийн болон ажилчдын унд-ахуйн хэрэглээний усыг хангаж байна.

**Ургамлан нөмрөг:** “Дулааны аргаар мах боловсруулах” үйлдвэр нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрийн ургамал-газарзүйн мужлалаар авч үзвэл Евроазийн шилмүүст ойн мужийн, өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрогт, харин Н.Өлзийхутагийн Ургамал газарзүйн тойргоор авч үзвэл Хэнтийн уулын тайгын тойрогт хамаарагдана. Энд алаг өвс-бутлаг

үетэн, алаг өвст хээрийн, алаг өвс-улалж-биелэг өвс-үетэнт, хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл зонхилох бөгөөд олон зүйлийн ургамлан нөмрөгтэй бүс нутагт багтдаг.

### **Нийгэм-эдийн засаг**

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болох Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо нь 759 өрхийн 2701 хүн амтай, зүүн хэсгээрээ 22-ын товчоо болон, 20-р хороо, урд талаараа Сонгино хайрхан уулаар, зүүн урдуураа Төв аймгийн Алтан булаг сумын Хустайн нуруу, Хурганы сангийн аж ахуйн баруун талаар Төв аймгийн Баянцогт сумын хүй долоон худаг, хойгуураа Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, зүүн хойд талаараа 22-р хороо тахилтын хэсэгтэй холбогдсон өргөн уудам нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэр нь тэгш, нам дор байрлалтай ба баруун талаараа чулуурхаг, газрын төлөв байдал чанарт өөрчлөлт ороогүй гадаргатай, голын голдирол даган үерийн аюул орж болзошгүй бүстэй. Нийт газар нутгийн хэмжээ 235 мянган га газар нутагтай.

Тус хороонд “Улаанбаатар буян” ХХК, Сонгинохайрхан үйлчилгээний төв, “Цэцэн хүү”, хүүхдийн цэцэрлэг зэрэг 72 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хорооны “Жаргал өлзий” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар жилд давхардсан тоогоор 3500 гаруй хүнд эмнэлгийн анхан шатны үйлчилгээг хүргэж байна.

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, ус, хөрс, ургамлын нөмрөг юм.

### 2.1.Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 2.Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х							
Гадаргын урсцын өөрчлөлт			х							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х					х
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х					х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			х							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг			х							
Бэлчээрийн байдал			х							
Эрдэс түүхий эдийн нөөц			х							
Эрчим хүчний нөөц			х							
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х							
Гадаргын усны чанар хэмжээ			х							
Агаарын бохирдол			х							
Хөрсний бохирдол			х							

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x		x					
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
<b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	21	0	11	0	5	0	2	8

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;



*Хүчтэй нөлөөлөл:*

Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Жэй Эйч Жэй Мандухай” ХХК нь “Дулааны аргаар мах боловсруулах” үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд БОННУ-ий тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах талаар явуулах үйл ажиллагаа нь дараах талбаруудад чиглэгдвэл зохино. Үүнд:

- Үйлдвэрийн бүх ажлыг аюулгүй ажиллагааны дүрмийн заалтын дагуу хийх
- Үйлдвэрийн талбайд ашиглалтын улмаас үүссэн болон ахуйн хог хаягдлыг цаг тухайд нь цэвэрлэх, хогийн цэгийн ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх.
- Гал түймрээс сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллах
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсдад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх, түүнчлэн хөрсийг ус ба салхины нөлөөгөөр элэгдэл эвдрэлд орохоос хамгаалж тарималжуулах болон бусад хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай.

Хүснэгт 3. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Зардлын ангилал	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	100.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	400.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1050.0
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	680.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	-
Нийт төсөв, мян.төг		<b>2330.0</b>

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **2330.0** мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1.	Үйлдвэрийн орчимд тоосжилт үүсгэх	Зам талбайг хатуу хучилттай болгохоос өмнө тоосжилт үүсгэж болохуйц талбайг хуурайшилт, салхи ихтэй үед усалж чийглэх арга хэмжээ авах	Үйлдвэрийн ажилчдад Төслийн талбайн тоосжилтыг бууруулах	-		-		-	Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
2	Үйлдвэрийн нам даралтын уурын зуухнаас угаа ялгарах	Нам даралтын уурын зууханд зөвхөн сайжруулсан шахмал түлш хэрэглэх, шахмал түлш үйлдвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулан ажиллах	Үйлдвэрийн нам даралтын уурын зуух	-		-		-	✓ Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ) MNS 4585:2016 (Гадна агаарын ЗДХ) ✓ Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5216:2016
3		Нийслэлийн агаарын чанарын албанд хандаж уурын зуухны яндангаас ялгарч буй угаа нь холбогдох стандартын ЗДА-ын хүрээнд байгаа эсэхэд дүгнэлт гаргуулах	Үйлдвэрийн нам даралтын уурын зуух	-	ОХШХ-ийн зардалд тусгав.			-	
<b>Хөрс, ургамлан нөмрөг</b>									
4	Үйлдвэрийн барилга байгууламжийн ажлын үед эдэлбэр газрын хөрс элэгдэж эвдрэн, ургамлан	Жил бүрийн БОМТ-нд нөхөн тарилт хийх, ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх талаар төлөвлөж зардлыг тусган гүйцэтгэх	Төслийн хэмжээнд	-	100.0	-	100.0	Жил бүр	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	нөмрөг доройтсон								
Нийт зардал							100.0		
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
5	Газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Цэвэр усны зүй зохисгүй хэрэглээг зогсоох, ажилчдад ус хэмнэх арга, ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	Төслийн хэмжээнд	-			-		Усны тухай хууль, 2012 он Ундны усны чанарын стандарт MNS 0900:2018 Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
6		Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах шингэн хаягдлыг цэвэршүүлэн стандартад нийцүүлэн зайлуулах	Төслийн хэмжээнд				-		MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 6561 : 2015
Нийт зардал							100.0		



## 5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд “Жэй Эйч Жэй Мандухай” ХХК нь нэгдэж 50 ш мод тарина.

Хүснэгт 5. Орчны хяналт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Хайлаас	Төслийн талбайн хэмжээнд	Ширхэг	50	8000	400,000	2023 он	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
2	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/	Ажилчны хөлс	Ажилчин	3		Үйл ажиллагааны зардал	2023 он	
<b>Нийт зардал</b>							<b>400 000</b>		

## 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Хэрэв үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн талбай	-	Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	2023 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
2	Палеонтологийн дурсгал							
<b>Нийт зардал</b>						-		

## 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	ХХАА-ны дүрэм журам зөрчигдөж үйлдвэрийн осол гарах	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах	Төслийн хэмжээнд	-	100.0	100.0	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94 Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94
2.	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж үйлдвэрийн доторх хананд байршуулах	Төслийн хэмжээнд	-	-	-		Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94
		Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Төслийн хэмжээнд	-				Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94
		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн хэмжээнд	-				Гал гарах үед анхааруулгын самбар, объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566: 2005
<b>Нийт зардал</b>						<b>100.0</b>		

## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн хатуу хог хаягдлаар орчныг бохирдуулах	Ахуйн хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис цацаж тогтмол ариутгаж байх	Төслийн хэмжээнд	-	550.0	-	550.0		Хог хаягдлын тухай хууль, 2017 он Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 Хаягдлын цэгийн стандарт MNS 5906:2015 Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, ЗГ-ын 2018 оны 116-р тогтоол Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх 2200/22 тоот гэрээ
		Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг дүүргийн тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу зөвшөөрөгдсөн хаягдлын цэг рүү тээвэрлэн зайлуулах, хог хаягдлын төлбөр тооцоог тогтсон хугацаанд төлж байх			500.0	-	500.0		
2.	Шингэн хаягдал	Үйлдвэрийн ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдлыг бохир ус зайлуулах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах	Төслийн хэмжээнд		Гэрээний үнийн дүнгээр				- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. - MNS 6561: 2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага”
